



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 01 өдөр

Дугаар 1/405

Хэрлэн сум

Шагнаж, урамшуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.16 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.5, 58 дугаар зүйлийн 58.2.20 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 3 дугаар сарын 03-ны 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2021-2022 оны хичээлийн жилийн Элсэлтийн ерөнхий шалгалтад амжилттай оролцож, 800 болон 780-аас дээш оноо авсан сурагчдыг хавсралтад дурдсаны дагуу шагнаж, урамшуулсугай.

2.Шагнагдах сурагчдын нэрсийг хавсралтаар баталсугай.

3.Шагналд шаардагдах 18,000,000 (Арван найман сая) төгрөгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн "Чадварлаг багш чанартай боловсрол"-ыг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Өнөрцэцэг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022
оны 11 дугаар сарын 01-ны
А/405 захирамжийн хавсралт

Шагналд шаардагдах төсөв

№	Сурагчдын нэрс	Хичээл	Сургууль	Шагнал
1	Баярцогт Удвал	Нийгэм судлал	Бэрх ЕБС	2.000.000
2	Мөрөнсaiхан Энхтуул	Нийгэм судлал	Тэмүүжин ЦС	2.000.000
3	Идэрбат Эрхтөгөлдөр	Англи хэл	Хэрлэн 1	2.000.000
4	Батбаяр Золжаргал	Монгол хэл	Хэрлэн 1	2.000.000
5	Эрдэнэхуяг Мөнхболор	Монгол хэл	Хэрлэн 1	2.000.000
6	Пүрэвдорж Наранмандах	Монгол хэл	Биндэр	2.000.000
7	Ганцогт Хариун	Англи хэл	Хэрлэн 1	1.000.000
8	Баяр-Эрдэнэ Хулан	Математик	Хэрлэн 1	1.000.000
9	Батбаяр Батцэцэг	Монгол хэл	БӨЦС	1.000.000
10	Базарваань Өлзийжаргал	Монгол хэл	Өмнөдэлгэр	1.000.000
11	Цогтбаяр Болоржин	Орос хэл	БӨЦС	1.000.000
12	Амарсайхан Дөлгөөн	Орос хэл	БӨЦС	1.000.000
		Нийт		18.000.000